



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 08 сарын 28 өдөр

Дугаар 2/448

Хэрлэн сум

Арга хэмжээнд хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.10 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Япон Улсын Токушима мужийн гамшгийн үеийн аюулгүй байдлын дадлага сургуулилтад оролцож, аймгийн Онцгой байдлын газрын гамшигтай тэмцэх үйл ажиллагаанд шаардлагатай техник тоног, төхөөрөмжийн дэмжлэг авч ажиллах нөхцөл боломжийг сайжруулах, мужийн захиргааны хамтын ажиллагааны арга хэмжээнд зориулж 20,100,000 (хорин сая нэг зуун мянган) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2. Хөрөнгө зарцуулалтын тооцоог хавсралтаар баталсугай.

3. Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг Засаг даргын хуулиар олгогдсон бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбоотой урьдчилан төлөвлөж төсөвт тусгах боломжгүй нэг удаагийн шинжтэй арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д зөвшөөрсүгэй.

4. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Л.Батсайхан)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ



Аймгийн Засаг даргын 2023 оны
дугаар сарын 08-ны өдрийн
дугаар захирамжийн хавсралт

Зардлын тооцоо

Д/д	Зардалын нэр/ төрөл	Тоо, хэмжээ	Нэгжийн үнэ	Дүн
1	Арга хэмжээнд оролцогчидын зардал	6	3350000	20100000